

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2019 ОНЫ НАЙМДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2019.07.26-2019.08.25/

2019 оны 08 дугаар сарын 26-ний өдөр

Дорнод аймаг

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хийгдэх ажил	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
Нэг. Захиргаа, удирдлагын чиглэлээр				
1	Орон нутгийн өөрөө удирдах төрийн захиргааны болон хууль хяналтын бусад байгууллагаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн олон нийтийн ажилд оролцох	а) Холбогдох албан хаагч нарыг хамруулах б) Шаардлагатай мэдээ, мэдээллийг харилцан солилцох,	<p>Дорнод аймгийн Засаг даргын удирдамжаар баталсан Түүхт Халх голын ялалтын 80 жилийн ойн баярыг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хуралд оролцсон.</p> <p>Дорнод аймгийн хэмжээнд энэ оны 07 дугаар сарын 27, 28-ны өдөр зохион байгуулагдсан “Зүүн бүсийн их хурд баяр наадам”-ын арга хэмжээний “Шагайн харваа”-ны тэмцээн зохион байгуулах хорооны даргаар бүсийн газрын дарга Б.Тамир томилогдон ажилласан бөгөөд хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, жолооч Т.Алтанпүрэв нар аймгийн Шагайн харвааны холбооны тэргүүн, гишүүдийн хамт тэмцээнийг амжилттай зохион байгуулан, дүн мэдээ тайланг Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар хүргүүлсэн.</p> <p>Аймгийн засаг даргад нутгийн иргэдийн төлөөллөөс Дорнод Аймгийн Матад сумд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй “Петроматад” ХХК-ийн үйл ажиллагааны талаар ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу аймгийн хууль хяналтын байгууллагуудын удирдлагуудын хамт хуралдан, мөн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хамтран зохион байгуулсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг 08 дугаар сарын 23-ний өдрийн 16-18 цагийн хооронд Дорнод аймгийн ЗДТГ-т зохион байгуулагдсан “Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдэвт уулзалтад ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн-Урсгал, мэргэжилтэн А.Нэмэхбаяр нар оролцсон.</p>	100%
2	Байгууллагын даргын болон бусад холбогдох нэгжээс ирүүлсэн үүрэг даалгавар, албан даалгавар, зөвлөмжийг	а) Албан хаагчдад хүргүүлж, үүрэг даалгавар өгөх	Газрын дарга даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна. Байгууллагын даргын 2019 оны А/75, А/94, 2018 оны А/144 тушаалын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллах, хилийн боомтоор зорчигч гадаадын иргэний	100%

	хэрэгжүүлж биелэлтийг гаргаж хүргүүлэх	б) Хэрэгжилтийг тухай бүр хангах в) Холбогдох албан тушаалтанд тайлагнах	хяналтыг сайжруулах үүднээс албан хаагчдад 12/90 тоот албан бичгээр тодорхой үүрэг чиглэл өгч ажилласан.	
Хоёр. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр				
3	Бүсийн газрын архивын өрөө, хадгаламжийн нэгжүүдийг цэгцлэх	а) Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлах б) Хадгаламжийн нэгжүүдийг архивт хүлээн авах в) Самбар хийлгэх	Тус сард Зүүн бүс дэх газрын ББНШК /Баримт бичиг нягтлан шалгах комисс/ хуралдаж тус Бүсийн газрын 2019 онд хөтлөх хэргийн жагсаалтыг нэгж тус бүрээс гаргуулан авч нэгтгэн байгууллагын удирдлагаар батлуулахад бэлэн болгосон. Мөн энэ хуралдаанаар 2018 онд хөтөлж бүрдүүлсэн Байнга хадгалах 18, 70 жил хадгалах 3, түр хадгалах 132 нийт 154 нэгжийг архивт хүлээн авахаар хуралдан шийдвэрлэсэн. 90*120 харьцаатай А4-н найман нүдний самбар хийлгэж архивийн өрөөнд байрлуулсан.	100%
Гурав. Нийгмийн баталгааг хангах чиглэлээр				
6	Албаны байрны хашаанд их цэвэрлэгээ хийх.	а) Зэрлэг ургамлыг зулгааж авах б) Ургаагүй гацуур модыг өөр модоор сольж суулгах	Албаны байрны хашаанд зэрлэг ургамал ургаж өнгө үзэмж дарсан байсныг байгууллагын жижүүр, үйлчлэгч, жолооч нар зулгааж цэвэрлэсэн. Хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын ая тух, амьдрах нөхцлийг сайжруулах үүднээс ОХУ-тай хил залгаа Ульхан боомтын амралтын байрны хана, шал, таазыг дулаалж, цахилгааны монтажийг шинээр хийн, өнгө будгийг сэргээж засварласан. Энэ тухай танилцуулгыг байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.	100%

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР